



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/ЗН8

Арвайхээр

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянтээг ХК-ийн нүүрсийг коксжуулж, Био холбогчтой бүрэн шаталттай шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэрийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Нэмэхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: - Т.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Г.Баясгалан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Л.Энх-Отгон (Баянтээг ХК-ийн ерөнхий инженер)

Ш.Авирмэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн) (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100554